



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/167

Ховд


Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн нийгмийн ажилтны өдрийг тохиолдуулан хүүхдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, сурч боловсрох боломж нөхцөл бүрдүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйлсэд өөрийн сэтгэл, оюун, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн Д.Октябрь, Ерөнхий боловсролын Цаст-Алтай сургуулийн нийгмийн ажилтан Ж.Бат-Орших, Жаргалант сумын Хайрхан багийн нийгмийн ажилтан Н.Дэлгэржаргал нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ариунболд), Ерөнхий боловсролын Цаст-Алтай сургуулийн захирал (Х.Гантөмөр), Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Баярлах) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 0217
Zah A/167 Kh